



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А133

Сангивцдолой

Гэрэгэ Киоск төхөөрөмж нийлүүлэх гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Улсын бүртгэлд Гэрэгэ Киоск төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг "Гэрэгэ Киоск ХХК"-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Дээрх ажилтай холбогдон гарах зардал 5,500,000 (таван сая таван зуун мянган) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.
3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА

